

Аймгийн Засаг даргын 2018  
оны 02 дүгээр сарын 28-ны өдрийн  
А/146 дугаар захирамжийн хавсралт

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2018.02.28

Мөрөн

Д/ д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
			Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хэрэгжих хугацаа		
<b>НЭГ. АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ САНАЛ САНААЧЛАГА</b>						
1.	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авилагатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.	1.1.1 Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх	-Төлөвлөгөө батлагдаж биелэлт хугацаандаа хэрэгжсэн байх. -Хэрэгжүүлсэн ажлын явц, биелэлтийг тухай бүр өөрийн нэгжийн болон байгууллагын цахим хаягт нийтэлсэн байх	2018.03.01 дотор	Аймаг, сумын ЗДТГ, байгууллага ОНУУГ	Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилт хангагаж, иргэд олон нийтэд Авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээлэл хүрсэн байна.
		1.1.2 Хөвсгөл аймгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын явц, биелэлт, үр дүнг байгууллагын цахим хуудаст тухай бүр нийтэлж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох сумд, байгууллага, газар, хэлтсээс гаргуулан авч, цахимд мэдээллийг нийтэлсэн байх.	Жилдээ		

		1.1.3. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах (мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал )г.м	ОНӨҮГ, байгууллага, сумд авлигын эсрэг хууль тогтоомжийг байгууллага, иргэдэд сурталчилсан байх	жилдээ		
2.	Алба хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	1.2.1. Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар сургалт зохион байгуулах	-Нийт албан хаагчид сургалтанд хамрагдсан байх	жилдээ	Байгууллагын удирдлага	Нийт албан хаагч сургалтанд хамрагдаж, Авлигын тухай мэдээлэл сайжирсан байна.
		1.2.2 албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр зайны болон танхимын давтан сургалтыг зохион байгуулах.	-Эрх бүхий албан хаагчид чиглэлийн сургалтанд хамрагдсан байх.	Жилдээ	Засаг дарга,ЗДТГ, байгууллагын дарга, удирдлагууд	
		1.2.3.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох, байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ	-Албан хаагчид ажлаа шударгаар үнэлүүлэх, авлигын зөрчил үүсэхгүй байх	Жилдээ		

**ХОЁР. ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРЭГ БОЛОН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

3.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд.	2.3.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах, хяналт тавих.	-Авлигын эсрэг хууль тогтоомжийг системийн хэмжээнд сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м /	Жилдээ	Засаг дарга, ЗДТГ, байгууллагын дарга, удирдлагууд ИНБ	Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа сайжирна. үйл
		2.3.2. Сум, байгууллага газар, хэлтэс цахим хуудас болон орон нутгийн мэдээллийн хэргэслээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг боломжит хэлбэрээр сурталчилах				
		2.3.4. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах	-Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар иргэд, байгууллага болон албан хаагчид мэдээлэлтэй болсон байх -Сурталчилгааны материал тараагдсан байх.	Тухай бүр		
4	Алба хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох.	2.4.1.. Албан хаагчдын ажил үр дүнг Төрийн албаны зөвлөлийн 134-р тогтоолыг баримтлан үнэлж, дүгнэх.	-Шалгуур үзүүлэлтийг баримтлан ажил, үр дүнгийн гэрээг дүгнэсэн байх.	жилдээ	Засаг дарга, ЗДТГ, байгууллагын дарга, удирдлагууд	Албан хаагчдын ажил үүргийн хуваарь тодорхой болж, албан хаагчдын ажлын үр дүнг, холбогдох хууль, журмын хүрээнд
		2.4.2. Байгууллагын бүтцийн нэгжийн ажил үүргийн чиглэлийн талаарх	Албан хаагчдын хариуцсан ажил үүрэг иргэдэд нээлттэй	Жилдээ		

		мэдээллийг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах	хүрсэн байх			дүгнэж, ажлын бүтээмж сайжирна.
5	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах.	2.5.1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, бүртгэн мэдээллийн санд оруулж, шийдвэрлэлтийг цахим хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, шийдвэрлэлтэнд удирдлагын зүгээс байнга хянаж, хүний зөрчигдсөн эрх, эрх чөлөөг хангаж ажиллах.	-Гомдол мэдээллийг хүлээн авч, бүртгэж мэдээллийн санд оруулсан байх -Удирдлагын зүгээс байнга хянаж байх -Иргэдийн зөрчигдсэн эрх хангагдсан байх	Жилдээ	Засаг дарга,ЗДТГ, байгууллагын дарга, удирдлагууд	Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилөн сэргийлэх тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
		2.5.2. Төрийн байгууллагад биеэр хандаж ирсэн иргэнийг угтах “Нэг цонхны үйлчилгээ”-г боловсронгуй болгох, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, байгууллагын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, иргэд, олон нийтийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх.	-Төрийн үйлчилгээ олон нийтэд чирэгдэлгүй, шуурхай хүрсэн байх	Жилдээ		
		2.5.3 Төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, авлига, хүнд суртлын талаар бичгээр ирсэн гомдолд шалгалт хийж, шийдвэрлэж байх.	-Гомдол, мэдээллийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулсан байх -Нууц задруулсан тохиолдолд хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжсэн байх	жилдээ		

		2.5.4 Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, харилцах утас, иргэнийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулах, дүнг олон нийтэд цахим хуудсаар мэдээлэх.	-Мэдээлэл цахим хуудаст нийтлэгдэж, иргэд, олон нийт мэдээллээр хангагдсан байх	Жилдээ		
6	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	2.6.1. Албан хаагчдаас авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон, зуучилсан талаарх мэдээллийг тухай бүр харилцан солилцож, хамтран ажиллаж, мэдээллийг харьяаллын дагуу хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллах.	-Мэдээллийг тухай бүр харилцан солилцож хамтран ажилласан байх -Мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлүүлсэн байх	Жилдээ	Байгууллагын удирдлага	Авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа сайжирна. үйл
		2.6.2. Сум, байгууллага, газар, хэлтэс салбар, нэгжийн ЭБАТ-ууд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, харьяа орон нутгийн захиргааны болон бусад байгууллагатай хамтран албан хаагчдад танхимийн сургалтыг зохион явуулах.	-Сургалт зохион байгуулагдаж, албан хаагчид бүрэн хамрагдсан байх -Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байх	Жилдээ		

7	<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах.</p>	<p>2.7.1. Албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.</p>	<p>-Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийг хүргүүлсэн байх</p>	<p>Жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор</p>	<p>Аймгийн ЗДТГ-ын ЭБАТ</p>	<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангагдана.</p>
		<p>2.7.2. Шинээр томилогдож байгаа төрийн алба хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулсны дараа томилж байх, тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч цахим санд бүртгэх</p>	<p>-Тухай бүр мэдүүлэг гаргагчид зөрчлийг арилгах талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, зөрчлийг арилгасан байх</p>	<p>Тухай бүр</p>	<p>Тухайн байгууллагын ЭБАТ-д</p>	
		<p>2.7.3 Төрийн албан хаагчдаас Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч цахим санд бүртгэх</p>	<p>-Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх -Мэдэгдэл тайлбар цахимд бүрэн бүртгэгдсэн байх</p>	<p>Тухай бүр</p>		

8	<p>Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах</p>	<p>2.8.1. Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран алба хаагчдад сургалт зохион байгуулах.</p> <p>2.8.2.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх</p>	<p>-Нийт албан хаагчид сургалтанд хамрагдсан байх</p> <p>-Тодорхой үйл ажиллагаа хэрэгжиж, үр дүнд хүрсэн байх</p>	Тухай бүр	Байгууллагын удирдлага, ИНБ	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах цар хүрээ нэмэгдсэн байна.
9	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх.</p>	<p>2.9.1.Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагчийн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалган тогтоох.</p> <p>2.9.2. Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, сургалтыг зохион байгуулах</p>	<p>-Албан хаагчийн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, шалган тогтоож, шийдвэрлэсэн байх</p> <p>-Албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ажил зохион байгуулж, үр дүнд хүрсэн байх.</p>	Жилдээ	Тухайн байгууллагын ёс зүйн хороо	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангагдана.
10	Байгууллагын	2.10.1.Байгууллагын		Жилдээ	Байгууллагуу	

	<p>удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах.</p>	<p>удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулсанаас бусад тушаал, захирамжийг цахим хуудсанд тухай бүр байршуулах.</p>	<p>-Мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байх</p>		<p>дын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан болон мэргэжилтэн</p>	<p>Удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдал хангагдана.</p>
		<p>2.10.2 Байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.</p>				
		<p>2.10.3. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөрт үйлчилгээ, төлбөр болон хураамжийг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах.</p>				
11	<p>Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах</p>	<p>2.11.1. Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг сурталчлах</p>	<p>Хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны мэдээлэл олон нийтэд хүрсэн байх</p>	<p>Тухай бүр</p>	<p>Байгууллагын удирдлага</p>	<p>Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа сайжирсан байна.</p>
12	<p>Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.</p>	<p>2.12.1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээлэл өгөх, үйл ажиллагааг ил тод нээлттэй явуулах.</p>	<p>-Төрийн үйлчилгээ түргэн шуурхай хүргэгдсэн байх</p>	<p>жилдээ</p>		<p>Төрийн албаны нээлттэй байдлыг хангасан байх.</p>



13	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх Албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.	2.13.1. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийлгэх ажлыг зохион байгуулах.	Байгууллагын үйл ажиллагаанд “Хэрэглэгчийн үнэлгээ” хийлгэсэн байх.	Тухай бүр	Байгууллагын удирдлага	Төрийн байгууллагаар үйлчлүүлж буй хэрэглэгч, иргэд, олон нийтийн хандлага, түүнд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйл, цаашид анхаарах асуудлыг тодорхойлно.
		2.13.2.Хамтран ажилладаг байгууллага, албан тушаалтан, иргэдээс хэрэглэгчийн үнэлгээний талаарх судалгааг авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах.	-Үнэлгээний судалгааны дүнд хэрэгжүүлэх ажлыг санал гаргаж, үр дүнд хүрсэн байх			
<b>ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХҮРЭЭНД:</b>						
14	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах.	3.14.1.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудсанд хариуцан оруулах мэдээллийн ажилтан, албан хаагчдаар мөрдүүлэх.	-Цахим хуудасны мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагаа хангагдсан байна.	Жилдээ	Байгууллагын удирдлага, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
		3.14.2.Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын khovsgol.gov.mn цахим хуудас болон албан байгууллага, сумдын мэдээллийн шинэчлэлтийг сайжруулах	Мэдээлэл байнга шинэчлэгдсэн байна.			
15	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах,	.15.1. Сул орон тооны зарыг цахим хуудсанд тухай бүр	-Хүний нөөцийн ил тод байдлаар	Тухай бүр	Төрийн албаны	Хүний нөөцийн ил тод байдал

	олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	шинэчлэн байршуулах.  3.15.2 Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох хуулийн хэрэгжилтийг хангах.  3.15.3 Ажилд авах, албан тушаал дэвшүүлэх, гадаад, дотоодод суралцуулах, шагнах, урамшуулах зэрэг сонгон шалгаруулах үйл ажиллагаа, журмуудыг нийтэд ил тод байлгах, оролцогч бүрийг ижил тэгш мэдээллээр хангаж, шударгаар шийдвэрлэх.	шударгаар бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг албан хаагч нар бүрэлдүүлсэн байх -Хууль, журамд заасны дагуу албан тушаалын томилгоо хийгдсэн байх		салбар зөвлөл	хангагдаж,холбогдох хууль, журмын хүрээнд албан тушаалын томилгоо хийгдсэн байна.
<b>ДӨРӨВ.ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР</b>						
16	Төсвийн орлого зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хувиаралалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	4.16.1.Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх	-Тухайн мэдээллүүд цахим хуудсанд байршуулсан байх  -Төсвийн хөрөнгийн төлөвлөлт,зарцуулалт	01 дүгээр сарын 15-ны дотор	СТСХ	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангагдсан байх

		4.16.2.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулсан байх	үр ашиг сайжирсан байх -Аудитын дүгнэлтийн хэрэгжилт сайжирч, зөрчлийг арилгасан байх -Төсвийн төсөлд иргэдийн санал тусгагдсан байх	04 дүгээр сарын 01-ны дотор		
4.16.3.Дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд байршуулсан байх	09 дугаар сарын 15-ны дотор					
4.16.4. Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудсанд байршуулах	04 дүгээр сарын 01-ний дотор					
4.16.5.Төсвийн байгууллагын тухайн жилийн төсвийн төсөлд (улсын болон орон нутгийн) олон нийтийн саналыг авч тусгах, хэрхэн тусгасан талаар мэдээлэх, цахим хуудсанд байршуулах	Жилдээ	ХОХБТХ				

		4.16.6.Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх	Төсөл, арга хэмжээний явц, үр дүнгийн талаар мэдээлэгдсэн байх	Тухай бүр	ХОХБТХ	
17	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	4.17.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах 4.17.2.Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах	Олгогдсон тусгай зөвшөөрлүүд, шаардлагатай баримт бичгийн жагсаалт, журмууд ил тод нээлттэй байршуулагдсан байна.	Тухай бүр	ХОХБТХ	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангагдсан байх

18	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	4.18.1.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	-Зарыг цахим хуудсанд байршуулсан байх -Хяналт шалгалтын дүнг цахимд байршигдсан байх -Төлөөллийг оролцуулсан байх -Хорооны бүрэлдэхүүнийг мэргэжлийн чадварлаг албан хаагчдаар бүрдүүлсэн байх	Жилдээ	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал хангагдаж, иргэд олон нийтэд худалдан авах үйл ажиллагааны мэдээллэл хүргэгдсэн байна.
		4.18.2.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах				
		4.18.3.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх				

**ТАВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

19	АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн албан бичгийн	5.19.1 Авлигатай тэмцэх газраас зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар ирүүлсэн албан бичиг, мөрдөн байцаагчийн мэдэгдлийг тухай бүр хариуг хүргүүлэх	АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар ирүүлсэн албан хэрэгжилтийг хангаж,	Тухай бүр	Байгууллагын удирдлага, Авлигатай тэмцэх орон нутгийн дэд зөвлөл ЭБАТ	АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах, хариуцлага тооцуулахаар ирүүлсэн албан
----	-----------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------	-----------	-----------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------

	хэрэгжилтийг хангах.	5.19.2. Цаашид тус газраас ирүүлсэн албан бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	Үр дүнд хүрсэн байх			бичгийн хэрэгжилт хангагдсан байна.
--	----------------------	------------------------------------------------------------------------------------------	---------------------	--	--	-------------------------------------

### Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-гийн “а” заалт, Авлигын эсрэг тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2018 оны 12 сарын 31-ний дотор аймгийн ЗДТГын Хууль Эрх зүйн хэлтэст ирүүлэхийг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, захирал эрхлэгч нарт, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2019 оны 01 дүгээр сарын 20-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг ХЭЗХ-ийн дарга (Г.Гандэлгэр)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Сум, байгууллага, ОНӨҮГ-ын дарга нарт

Аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 146 тоот захирамжаар батлагдсан Хөвсгөл аймгийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө”-г хүргүүлэв.

Жич: Авлигатай тэмцэх газар нь уг төлөвлөгөөний биелэлтийг тухайн байгууллагын цахим хаягт дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөний биелэлтийг хянах тул төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг тухай бүр байгууллагын болон өөрийн нэгжийн цахим хаягт нийтэлж ажиллахад анхаарна уу.

ДАРГА

Л.ГАНБОЛД

